



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 09 сарын 03 өдөр

Дугаар А/324

Улаанбаатар хот

Хөтөлбөр батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь заалт, Иргэний нисэхийн үндэсний төвийн дүрмийн 5.4.8 дахь заалт, Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2018 оны А/773 дугаар тушаалаар батлагдсан "Ажилтнуудын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийн зорилт 5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэний нисэхийн үндэсний төв, түүний харьяа салбар нэгжийн ажилтнуудад үзүүлэх Коронавируст халдвар (КОВИД-19)-ын дараах дархлаа дэмжих, нөхөн сэргээх үйлчилгээний хөтөлбөрийг 1 дүгээр хавсралтаар, хөтөлбөрийн үнэ төлбөрийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Сэргээн засах амралт (Ж.Амарсүрэн)-д, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хүний нөөцийн газар (Р.Амарбаясгалан)-т тус тус үүрэг болгосугай.


3. Энэ тушаалыг 2021 оны 9 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ДАРГА



П.МӨНХЖАРГАЛ

Иргэний нисэхийн үндэсний төвийн даргын
2021 оны 09 дүгээр сарын 03 -ны өдрийн
А/324 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралт



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ, ТҮҮНИЙ ХАРЬЯА САЛБАР, НЭГЖИЙН АЖИЛТНУУДАД ҮЗҮҮЛЭХ КОВИДЫН ДАРААХ ДАРХЛАА ДЭМЖИХ, НӨХӨН СЭРГЭЭХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Нэг.Нийтлэг үндэслэл

Хөтөлбөрийн товч нэр: CARE хөтөлбөр
Хөтөлбөр хэрэгжүүлэгч: ИНҮТ-ийн харьяа Сэргээн засах амралт, ИНҮТ-ийн Гамшгаас хамгаалах штаб
Хөтөлбөр хэрэгжүүлэх хугацаа: 2021.09.01-2021.12.31
Хамрах хүрээ: Иргэний нисэхийн ерөнхий газар, түүний харьяа салбар нэгжийн коронавирусын халдвараар өвдсөн ажилтнууд

Хоёр.Хөтөлбөрийн зорилго

Дэлхий нийтийг хамарсан коронавируст халдвар КОВИД-19 цар тахлын аюул арилаагүй байгаа өнөөгийн нөхцөлд ЭМЯ, мэргэжлийн байгууллагаас ковидоор өвдөөд эдгэрсэн хүмүүст эрүүл задгай агаар, дасгал хөдөлгөөн, нөхөн сэргээх эмчилгээ сувилгаа зайлшгүй хэрэгтэй байгааг зөвлөсөн.

Иргэний нисэхийн салбарын ковидоор өвдсөн ажилтан, албан хаагчид, тэдгээрийн гэр бүлийн эрүүл мэнд, дархлааг дэмжих үүднээс эрүүл цэвэр агаар, тав тухтай орчинд сэтгэлзүйн стресс, алжаал ядаргааг тайлах, идэвхтэй хөдөлгөөн, нөхөн сэргээх эмчилгээгээр үйлчлэх зорилготой.

Гурав.Хөтөлбөрийн зорилт

- 3.1. Амарч буй ажилтан, албан хаагчдын сэтгэл ханамжийг өндөр түвшинд байлгах;
- 3.2. Амт чанартай, эрүүл хоол хүнсээр үйлчлэх;
- 3.3. Идэвхтэй хөдөлгөөнөөр дархлааг дэмжих (өглөөний дасгал, явган аялал);
- 3.4. Нөхөн сэргээх эмчилгээ, сувилгааг хийх (физик эмчилгээ, бариа засал);

Дөрөв."CARE" хөтөлбөрийн журам

- 4.1. Салбарын ажилтан ИНҮТ-ийн Гамшгаас хамгаалах штабаас олгосон эрхийн бичгийн дагуу үйлчлүүлнэ.
- 4.2. CARE хөтөлбөрт хамрагдах хугацаа Ням гарагийн өдрийн 12:00 цагаас Бямба гарагийн өдрийн 12:00 цагийн хооронд байна.
- 4.3. Сэргээн засах амралт руу холбогдож, өрөөний сонголтоо хийн захиалгаа баталгаажуулна.
- 4.4. Гэр буудалд байрлах амрагчийн тоо орны тооноос хэтрэхгүй байх ба 1 гэр буудалд зөвхөн 1 гэр бүлийн гишүүд байрлана.
- 4.5. Амрагч эрүүл аюулгүй байдлыг хангах үүднээс хувийн бэлтгэлээ хангаж ирнэ. /цагаан хэрэглэл, оо, сойз, алчуур, барианы даавуу, барианы тос гэх мэт/
- 4.6. Амралтын ресепшинд эрхийн бичиг болон ажлын үнэмлэхээ бүртгүүлж, гэр буудалдаа байрлана.
- 4.7. Хуваарийн дагуу:

2.

- Өглөөний хоол 09:00-10:00
- Өдрийн хоол 13:00-14:00
- Оройн хоол 19:00-20:00 цагуудад ресторанд хооллоно.

4.8. Эмчийн үзлэгт хамрагдан зөвлөгөө авах ба эмчийн зааврын дагуу эмчилгээнд цагийн дарааллаар үйлчлүүлнэ.

4.9. Тухайн амралтаас санал болгосон өглөөний дасгал, маршрутын дагуух явган алхалтад сайн дурын үндсэн дээр хамрагдана.

4.10. Амрах хугацаандаа архи, согтууруулах ундаа хэрэглэхийг хориглох ба бусад гэрүүд рүү орж бөөгнөрөл үүсгэхгүй байна.

4.11. Амрах хугацаандаа зөвшөөрөгдсөн тооноос хэтрүүлэн хүн нэмэхгүй байна.

4.12. Гэр буудлаа ресепшинд хүлээлгэн өгөх хүртлээ хүлээн авсан эд хогшлынхоо бүрэн бүтэн байдлыг хариуцна.

4.13. Амрагч, үйлчлүүлэгч энэхүү журамтай танилцаж, хавсралт хүснэгтэд гарын үсэг зурж баталгаажуулна.

Тав.Бусад

5.1. Ажилтан хөтөлбөрийн журмыг чандлан биелүүлэх үүрэгтэй.

5.2. Ажилтан хөтөлбөрийн журмын 4.12-т заасан заалтыг биелүүлээгүй тохиолдолд амралтын газрын дотоод журмын дагуу хохирлыг төлж барагдуулна.

5.3. Ажилтан амрах хугацаа дуусахад холбогдох тооцоог бүрэн төлнө.

--- оОо ---

